ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 10 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-15
1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	5-14
2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	14-15

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын 10 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан хуралдааны товч тэмдэглэл

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 32 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан, А.Ундраа, Б.Уянга, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, Х.Ганхуяг;

Тасалсан: П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Ц.Баатархүү, О.Батнайрамдал, Ж.Золжаргал, Э.Одбаяр, Г.Очирбат, Р.Сэддорж, О.Цогтгэрэл, С.Эрдэнэбат.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл,* ***эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Уганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Эрдэнэсамбуу, зөвлөх Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Жаргалан, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Уганбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

Н.Наранбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу ажлын хэсгийн гаргасан доорх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 12
Бүгд: 36
66.7 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дахин хураалгах санал дэмжигдлээ.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувьд тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 14
Бүгд: 36
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал:

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан 3 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**3 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 12
Бүгд: 37
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

Н.Наранбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан доорх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 14
Бүгд: 37
62.2 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дахин хураалгах санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 11
Бүгд: 37
70.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан доорх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 11
Бүгд: 37
70.3 хувь буюу гуравны хоёроос доошгүйн саналаар дахин хураалгах санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.2 дахь заалтын “3 хувиас” гэснийг “2 хувиас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 11
Бүгд: 37
70.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хороодын хуралдаанаас гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл */Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Эрдэнэсамбуу, зөвлөх Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Байнгын хороодын хуралдаанаас гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 43 минут үргэлжилж, ирвэл зохих 56 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 66.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Н.НАРАНБААТАР

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 10 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
10 цаг 34 минут.

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 57.1 хувьтай бүрдсэн тул 2026 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Ирсэн гишүүдийг танилцуулъя.

Норовын Алтанхуяг, Ринчиндоржийн Батболд, Жадамбын Баясгалан, Пүрэвжавын Ганзориг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Номин, Баттогтохын Чойжилсүрэн, Чинбаатарын Анар, Болдын Жавхлан, Ганзоригийн Лувсанжамц, Гончигдоржийн Уянгахишиг, Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвжавын Сайнзориг, Дашцэрэнгийн Энхтүвшин, Нацагдоржийн Батсүмбэрэл, Батбаярын Жаргалан, Бадамдоржийн Пунсалмаа, Мөнхчулууны Энхцэцэг, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жамбын Батсуурь, Жамбалын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Шинэбаярын Бямбасүрэн, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Лхагвасүрэнгийн Соронзонболд нарын гишүүд ирсэн байна.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. 1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар /ЗГ/ болон Улсын Их Хурал /УИХ/-ын гишүүн Тэмүүлэн нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг. 2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оноос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, ЗГ 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Засгийн газар болон УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл,* ***эцсийн хэлэлцүүлэг/***

Нэг дэх асуудал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Нинжбатын Уганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Галбадрахын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед олонхын дэмжлэг авсан зарим зарчмын зөрүүтэй саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг та бүхэнд тараасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Наранбаатар танилцуулна.

Монгол УИХ-ын даргын 2026 оны 330 дугаар захирамжаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оноос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2026 оны 10 дугаар сарын 5-ны өдөр хуралдаж, төслийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед дэмжигдсэн саналыг нэгтгэсэн төсөлд нэмж тусган, төслийн эцсийн хувилбарыг хэлэлцлээ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлд ажлын хэсэг дараах 2 асуудлаар санал хураалт явуулсан. Үүнд, 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалт буюу 6.1.3 дахь заалтыг ЗГ болон УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн хувилбараар өөрчлөх. Энэ саналыг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн Байнгын хороо хураах нь зүйтэй гэж үзлээ. 2.Нэгтгэсэн төслийн хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан 3 дугаар зүйлийг нэгтгэж, хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх нь зүйтэй гэж үзлээ. Энэ саналыг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн Байнгын хороо хураах нь зүйтэй гэж үзлээ. Учир нь энэ асуудлаар нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн болно. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн. Ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Ажлын хэсэг Наранбаатар, Ариунзаяа, Батболд, Болормаа, Булгантуяа, Жангабыл, Жаргалсайхан, Заяабал, Наранбаяр, Пүрэвдаваа, Сайнзориг, Цогтбаатар, Чинбүрэн.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбар болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Жаргалан гишүүн кнопоо дараарай, Жаргалан гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Энэ 6.1.2-ын нөгөө 2 хувь, 3 хувь болчихсон байгаа. Энэ чинь угаасаа дотоодын ний бүтээгдэхүүн чинь өөрөө байнга өсөж байгаа, дээрээс нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өөрөө өсөж байгаа тохиолдолд энэ 2 хувийг 3 хувь болгодог бол яалт ч үгүй байж болохгүй асуудал байна. Энэ дээр санал хураалт хэзээ явах билээ?

Н.Наранбаатар: Уг нь гишүүн өөрөө байвал татаад авчихмаар байдаг, нэг гишүүн санал гаргаад санал хураалгачихвал болох уу, дэгээр? Тэгвэл өөрөө хүрээд ир гээд хэлээдхээч. Энэ дээр татаж болох эсэх дээр нэг хуулийн тайлбар өгөөдөхье. Хэдүүлээ нэг сонсоодохъё, Гандулам зөвлөх. Хуулийн лавлагаа аваадахъя.

Б.Гандулам: Өнөөдөр Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа. Зарчмын зөрүүтэй саналаа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үед татаж авах боломжтой байсан, анхны хэлэлцүүлэг бол Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хийгдээд өнгөрчихсөн. Өнөөдрийн эцсийн хэлэлцүүлэг дээр дараах тохиолдолд Байнгын хороон дээр эцсийн хэлэлцүүлэг явуулахад санал хураалт явуулж болно гэсэн дэгийн зохицуулалт байгаа. Энэ 42.1 байгаа, 42.2.1. Энэ нь нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн тохиолдолд болно.

42.2.2 нь анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсвэл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасан тохиолдол гэж байгаа. 42.2.3 нь нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэж байгаа юм. Тэгээд энэ 3 тохиолдолд эцсийн хэлэлцүүлэг дээр дахин санал хураалт явагдах дэгийн хуулийн зохицуулалттай байгаа.

Н.Наранбаатар: Тэгнэ, одоо ингэнэ. Жаргалан гишүүн асуулт, санал гаргана. Дараа нь Ариунзаяа гишүүн санаачлагчийн хувьд тайлбар хийнэ, тэгээд дараа нь санал хураалт. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ЗГ-аас санаачилсан төсөл байгаа, мөн Тэмүүлэн тэргүүтэй 13 гишүүний санаачилсан төсөл байгаа. Би энэ гишүүдийн санаачилсан төслийн санаачлагчдын нэг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр энэ 6.1.2 дугаар заалт дээр тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай эсвэл ашигтай байх гэсэн заалт дээр энэ ДНБ-ий 2 хувь гэдэг агуулга ЗГ-ын төсөлд ч байгаа, мөн гишүүдийн төсөлд ч байгаа. Хэлэлцүүлгийн явцад энэ ашиг, алдагдлын хэмжээг ДНБ-ий 3 хувь болгоод ингэж огцом нэмэгдүүлчихсэн нь олон улсад мөрдөгдөж байгаа төсвийн тусгай шаардлагууд дээр ч гэсэн нийтлэг жишгээс ангид ийм санал болчихсон учраас энэ саналыг хуучнаар нь буюу ДНБ-ий 2 хувь дээр нь барих ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргах хүсэлтэй байгаа. Анхны хэлэлцүүлгийн явцад нэлээн олон гишүүдээс янз бүрийн зарчмын зөрүүтэй саналууд гараад, энэ төсвийн тусгай шаардлагууд тодорхой хэмжээнд өөрчлөгдсөн.

Тэгэхээр энэ ташрамд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуух нь, та бүхний дүгнэж байгаагаар энэ анхны хэлэлцүүлгийн хүрээнд шийдвэрлэгдсэн асуудлууд цаашдын Монгол Улсын төсвийн сахилга бат, тогтвортой байдалд хэрхэн, яаж нөлөөлөх вэ гэж та бүхэн маань үзэж байна? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ хуулийн өөрчлөлт дээр ямар байр суурьтай байна вэ гэдгээ

хэлж өгөхийг хүсье. Тэгээд энэ ДНБ /GDP/-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай эсвэл ашигтай байх гэсэн энэ асуудлыг энэ 2 хувиар нь үлдээж өгөхийг нийт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээсээ хүсэх байна.

Н.Наранбаатар: 1 номерын микрофон.

Н.Уганбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Уганбаатар. Энэ 3 саналтай холбоотойгоор Тогтвортой байдлын зөвлөл өөрсдийнхөө байр суурийг илэрхийлсэн жижигхэн 2 нүүр баримт бичиг гаргаад parliament.mn дээр удахгүй тавигдах байх. Тэндээс дэлгэрэнгүй танилцуулгатай та бүхэн танилцана биз. 3 ямар асуудал дээр бид нар санаа зовниод байгаа вэ гэхээр 1 дүгээрт, энэ саяын Жаргалан гишүүн болон бусад гишүүдийн хөндөөд байгаа тэнцвэржүүлсэн тэнцлийг 2 хувь байсныг нь 3 хувь болгох. Энэ санал дээр бид нэлээн эсрэг байр суурьтай байгаа. Цаад талынх нь ерөнхий агуулгыг бид бодоод үзвэл бид нар анх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн дүрмүүдийг анх оруулж ирэхдээ эдийн засгийн мөчлөгийг дагахгүйгээр эдийн засгаа цааш нь авч явъя гэдэг ийм зарчмын байр суурь дээр шийдвэр гаргасан байдаг. Ийм бидэнтэй төстэй тэнцвэржүүлсэн тэнцэл хэрэглэдэг өөр нэг улс бол Чили улс байгаа. Чили улс 2005 онд, 2000 онд энэ дүрмийг хэрэглэж эхэлсэн. 2000 онд энэ дүрмийг Чилийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 хувийн ашигтай байх ёстой ийм дүрэмтэй. 2000 онд энэ дүрмийг хэрэглэхэд Чилийн нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5 мянган доллар байсан бол одоо 17 мянга, 18 мянган долларт хүрсэн байдаг. Тэгээд судлаачид энэ дүрмийн ашиг тусыг өгсөн, энэ дүрэм ашиг тусаа өгсөн гэж үздэг. Энэ манайхтай ижил төстэй орнуудад зориулагдсан, түүхий эдийн циклийг дагаж төсөв нь хөдөлдөггүй байхаар макро эдийн засаг нь илүү тогтвортой байдаг байхаар зохион байгуулагдсан, зохицуулагдсан ийм дүрэм бөгөөд манай дүрэм Чилийнхтэй харьцуулбал хамаагүй сул ийм дүрэм байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, бид өнгөрсөн хугацаанд макро эдийн засгийнхаа ерөнхий төлөвийг харвал төсөв нь жоохон сул, мөнгө нь нэлээн чанга ингээд аягүй олон жил явж ирлээ. Эндээс ямар хүмүүс нь энэ дээр их аз жаргалтай байгааг хэлэхэд хэцүү. Эдийн засаг нь өсөөд байдаг, өрхүүдэд орлого нь орохгүй байна гээд байнга л энд яригддаг асуудлууд цаад талынх нь макро эдийн засаг талаасаа төсөв нь сул, мөнгө нь чанга байгаад л бүх асуудал байгаад байгаа юм. Уг нь энэ дүрмүүдээ бариад явах юм бол бид эсрэгээрээ байж чадах юм бол магадгүй 10 жилийн дотор нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ үнэхээрийн Чили шиг 3 дахин нугалах боломж, бололцоо нь харагдаад байгаа юм. Тэгээд 2 дахь асуудал бол энэ. Төсвөө чанга, мөнгөө сул, макро эдийн засгийн төлөв рүү, тэнцвэр рүү очмоор байна. Энэ рүү явах цорын ганц арга зам бол төсвийн тусгай шаардлагуудаа мөрдөх хэрэгтэй. Бид өнгөрсөн хугацаанд яг нэг их мөрдлөггүй яваад ирсэн тохиолдлууд аягүй олон байгаа, хэдүүлээ эргээд харах юм бол.

Дараагийн нэг асуудал бол дахиад дараа дараагийн дүрмүүд дээр хүндрэл учруулна. Тухайлбал өрийн тааз маань одоо орж ирсэн, 27 оны төсвийн төслөөр 50 хувь руугаа дөхчихсөн байгаа, 49 дээр 50 хувь руугаа дөхчихсөн байгаа. Мега төслүүдийнхээ тооцоог тооцоонд оруулаад ирэхээр энэ маань буцаад нөгөө 60 хувийн тааз руугаа бол тэртээ тэргүй 2 хувь дээрээ байхад тун удахгүй хүрнэ, 3 жилийн дотор ер нь хүрэхээр бид нарын тооцоо харагдаж байгаа юм. Тэгэхээр энэ дараагийн дүрэм дээр очоод дахиад хүндрэл учруулна, өрнийхөө тааз дээр аваачиж тулгана. Одоо бүх нийтээрээ та бүхэн дэлхийн санхүүгийн зах зээлийн мэдээг харж

байгаа бол ЗГ-ын өрийг хэрхэх вэ гэдэг асуудлууд маш олон хөгжилтэй орнуудын толгойны өвчин болоод байна. Өнөөдөр Францад болж байгаа асуудлууд, өнөөдөр ч биш аягүй олон жил, сүүлийн хэдэн жил төсвийнхөө сахилга батыг сайжруулъя гэж хэлсэн Ерөнхий сайд болгон тэнд огцроод байгаад байгаа юм. Ийм нөхцөл байдал руу хэдүүлээ явна. Тийм учраас энэ 2 хувиар, төсвийн тэнцлийнхээ дүрмээр бид нар өмнө нь бас нэг удаа оролдоод үзсэн 24 онд, тэгээд үр дагаврыг нь хэдүүлээ бас харцгаасан байх. Энүүгээр нэг их оролдох хэрэггүй болов уу гэсэн ийм байр суурьтай байгаа. Энийгээ бид нар албан ёсоор parliament.mn дээр тавьсан.

2 дахь асуудал нь 7.5-тай холбоотой асуудал байгаад байгаа, 7.5-аа уг нь авч үлдээд, тэгээд яах вэ, энэ жилийн төсөв дээр болохгүй бол нэг удаагийн ч юм уу зохицуулалт оруулаад явах боломж байгаагүй юм болов уу гишүүдээ? Энэ 7.5-ыг чинь авчихаар манай Үндсэн хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гээд нэг зарчим байдаг юм байна лээ, тэр зарчмыг амь оруулж байгаа цөөхөн хэдхэн заалтуудын нэг нь энэ байгаад байгаа байхгүй юу. 7.5 нь зөвхөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл биш Эдийн засаг, хөгжлийн яам, нөгөө 19 онд орж ирсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн хөгжлийн төрийг угсрах эхний оролдлогууд.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээж хариулъя.

Н.Уганбаатар: Энэ хэсэг дээр нэлээн ухралт гарчих гээд байгаа юм шиг ийм дүгнэлтийг бид нар бас гаргаж байгаа. Энийгээ эргээд харвал яасан юм бэ, 7.5-аа байлгаж байвал дээр юм биш үү?

3 дахь асуудал нь техникийн шинжтэй нэг зүйлийг бид нар хэлээд байгаа. Тэр нь 6.1.3 дээр шинэ зарлагын дүрэм орсонтой холбоотойгоор бид нар одоогийн энэ дэмжигдсэн төслөөрөө ч гэсэн тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ийг хэмжих шаардлага үүснэ. Тухайлбал 27 оны төсөв дээр энэ дүрмийг хэрэглээ гэвэл бидэнд 26 оны тухайн жилийн өмнөх учраас 26 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн тоо хэрэгтэй. Энэ тоо хаана ч байхгүй, энэ тоо 27 онд Үндэсний статистикийн газраас гарч ирнэ. Тийм учраас ирээдүйн нэг тоог ирээдүйн бас нэг байхгүй тоотой харьцуулах шаардлага үүсэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр төсвийн хүрээний мэдэгдлийнхээ үзүүлэлтүүд дээр 2.1.10 гээд 9 биш 10 дахь үзүүлэлтийг нь нэмээд, тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүрэлдэхүүний өсөлт гэдэг үзүүлэлтээ бид нар хавар хэлэлцээд баталчих юм бол.../минут дуусав/

Н.Наранбаатар: Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцож байгаа гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая. Миний хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл улс орны хөгжлийг гацаагч уу гэж хэлж байсан удаа бий. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 яг одоо Монгол Улс соёрхон баталчихсан байгаа 116 төсөл байна, гадаад зээл тусламжийн. Эдгээрээс 89 төсөл л одоо хэрэгжиж байгаа, зээлийн ашиглаагүй үлдэгдэл 14.5 их наяд, эдгээр зээлүүдийн 95 хувь нь 2030 онд дуусна. Энэ чөдөр тушаанаас болж бид гадаадаас авчихсан байгаа, хэдийнээ авчихсан байгаа зээл тусламжаа ашиглаж чадахгүй өдөр тутам хүүгийн төлбөр тооцогдоод, мөнгөний үнэ цэн унаж байгаа.

Ерөнхий сайд сая Японд айлчлаад ирэхдээ 1 тэрбум ам.долларын зээлийн хэлэлцээрт гарын үсэг зураад ирсэн, тэгээд яах юм бэ, одоо өргөн барьчихсан байгаа төсөв 2 хувьдаа тас яг барьчихсан байгаа. Ирэх онд энэ Японы зээлийн хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлах үед яах вэ, дахиад хаалганы гадуур гаргах уу, хивснийхээ доор хогоо шүүрдэж оруулах уу? 2 төслийг төсвөөс гадагш нь гаргачихсан гээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрөө энийгээ хүлээн зөвшөөрөөд ярьж байгаа, бодогддог юм уу тэгж, төсвөөс гадуур гаргачихлаа. Хэчнээн зээлийн хэлэлцээрийг төсвөөс гадуур гаргах юм ер нь, хэдэн төсөвтэй байх юм, энэ асуудлыг ярихгүй өөрсдийгөө хуурч болох юм уу? Ийм учраас би энэ саналыг гаргаж ажлын хэсэг дээр, УИХ-ын чуулган дээр уг нь дэмжигдсэн.

Олон улсын хэмжээнд төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн дундаж 3-аас 5 орчим хувь байдаг. Дэлхийн ерөнхий дундаж 3-аас 5 хувь, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын дундаж нь 4.6, Их 20 /G20/-ийн дундаж нь 3.9, манай улс ч гэсэн 2014 онд 2.8 байсан, тэрнээсээ өмнө бол бүр 2017 онд 10.4 хувь байсан. Тэгээд энэ улс хөгжих гээд байгаа юм уу, хөгжихгүй юм уу гэдэг л ийм асуудал. Урсгал зардал тэлэх нь нэг өөр, авсан байгаа зээлүүдээ хэрэглэхгүй юм уу нөхөд өө, 14.5 их наяд төгрөгийн зээл авчхаад бид нар хэрэглэж чадахгүй байна. Энэ чөдөр тушаанаас болж, үгүй ээ төсвөө үнэн зөв тайлагнаад явж болдоггүй юм уу гэдэг л ийм санаа байсан юм. Тэгээд эрхэм гишүүд маань.../минут дуусав/

Н.Наранбаатар: Ариунзаяа гишүүн гүйцээе.

А.Ариунзаяа: Төсөв маань зөв байгаасай, төсөв маань үнэн байгаасай, авсан хөгжлийн зээлээ хурдан түргэн хэрэгжүүлээсэй, олон улсын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс биелүүлээсэй гэдэг ийм л санаа байсан юм. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн та бүхэн маань нэг нүдээ илүү нээж, нүдний шилээ нэг жоохон арчмаар байна, 2 хөгжлийн зээлийг төсвөөс гадуур гаргасан нь өөрөө зөв явдал биш шүү би энийг хэзээд хэлнэ, огтоосоо зөв явдал биш, энэ өөрсдийгөө хуурч байгаа асуудал. Би нэг нүдээ дарж энэ асуудлыг нэг иргэдэд ойлгомжтой болгох гэж хичээсэн. Саналаа яах вэ эргүүлэн татъя гэсэн бодолтой орж ирлээ, гэхдээ болохгүй юм байна. Ийм учраас Байнгын хорооны гишүүд өөрсдийнхөө эрх мэдлийн хүрээнд энэ заалтыг өөрчлөх үү, үгүй юү гэдгийг шийд дээ. Тэгээд гол санаа бол энэ 2 хувийг 3 хувь болгодог нь.../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Зүгээр нэг тодруулах юм байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.6 дээр энэ 6.1.2 буюу саяын 2 хувьтай холбоотой заалтыг өөрчлөхийг, тэр өрийн хязгаартай холбоотой заалтыг өөрчлөхийг хориглоно гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр энэ одоо хэлэлцэж байгаа асуудал дээрх энэ өөрчлөлт юмнууд чинь энэ хуулийнхаа зүйл, заалттай нийцэж байгаа юм уу? Энийг хориглоно гэсэн ийм заалт байгаа юм.

Дээр нь зүгээр бас нэг юмыг сануулж хэлэхэд энэ төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагууд нь өөрөө энэ ЗГ-ыг сахилга баттай байлгах гэсэн гол манай ер нь ЗГ-тай хариуцлага тооцдог ганц бараг заалт, энэнээс үүдээд ЗГ-ын огцрох эсэх асуудлыг ярьж болох ийм хуулийн үндэслэлтэй заалт байгаа, хууль байгаа. Тэгэхээр энэний анх эхэлж энэ хуулийг хийхдээ нэлээн олон түгжээнүүдийг хийж өгсөн, тэрний нэг нь болохоор энэ 7.7 дээр бас яг энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль өөрчлөхөөр бол энэ асуудалд өөрчлөлт орохоор бол заавал

УИХ-ын гишүүд хуралдаа заавал ирж оролцоно гэсэн ийм хуулийн заалтууд байгаа. Тэгэхээр Байнгын хорооны даргын хувьд ч гэсэн гишүүдийг бас яг энэ хууль дээр ийм үүрэг байгаа учраас хуралдаанд оролцох ёстой гэдгийг нь сануулах ёстой байх гэж бодож байна. Тэгэхээр тэр 6.6 дахь заалттай энэ өөрчлөлтүүд нь нийцэж байгаа юу гэдэг талаар асуулт байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тогтвортой байдлын зөвлөл хариулах уу, хэн хариулах вэ? Хуулийн лавлагаа асууж байна шүү дээ. Зөвлөхүүд хариулах уу? 6.6-тайгаа нийцэх юм уу гэж асууж байна энэ өөрчлөлтүүд чинь. Тогтвортой байдлын зөвлөл хариулъя, 1 номер.

Н.Уганбаатар: Би ч хууль тайлбарлаж болж байна уу, үгүй юү. Тэгээд гишүүний дурдсан 2 заалт бол манай дүгнэлт дээр ч бас байгаа л даа, 6.1.2-т заасан тэнцлийг бууруулахыг хориглоно гээд байгаа. Тэгэхээр миний ойлголтоор бол хэрвээ тэнцлийн дүрэмд өөрчлөлт оруулах гэж байгаа бол, хэмжээг нь бууруулах хэмжээний өөрчлөлт оруулах гэж байгаа бол энэ заалттайгаа хамт хоёуланг нь хэлэлцэж байж, тэгээд энэ заалтаа хүчингүй болгох гэдэг дээр санал хурааж байж цаашаа явах нь зөв болов уу л гэж би ойлгож байна. Тэгэхгүй бол хуулийн зөрчил үүсэх байх.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би яах вэ, энэ 2 хувийг 3 хувь болгох дээр ажлын хэсэг дээрээ цөөнх болсон юм. Тэгэхдээ сая Ариунзаяа гишүүн бодит байдлыг хэлээд байна. Үнэхээр хэдүүлээ яг ийм эцсийн шатан дээр ирээд янз бүрийн юм ярихад жоохон хэцүү л байна. Нэг талаараа Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцэж байгаа энэ зээлийн шугамууд нээж байгаа энэ хэлэлцээрүүдээ зогсоох хэрэгтэй. Бүгд л уухайн тас дэмжээд л, ямар сайхан юм бэ, ямар ч найрсаг харилцаа байна ингээд л аваад байгаа шүү дээ. Би энийг л хэлээд байгаа юм. Зээлийн юм чинь ингээд тулчхаад байна, сүүлдээ арга ядаад энэ Нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэний энэ сэргээгдэх эрчим хүчний төслийг чинь явуулахын тулд анх Аубакир гишүүн, Ганхуяг гишүүн, Мөнхбаясгалан гишүүн бид 4 ч ингээд ийм юм хийлээ шүү дээ, тэгээд яг энийгээ одоо бодит байдлаар нь оруулаад тооцъё, энийгээ буцаад төсөв дээрээ оруулъя гэвэл 3 хувь чинь угаасаа байж байгаа байхгүй юу. Тэгээд яг л нэг өөрөө өөрсдийгөө хуураад л, яах вэ тийм л байгаа, зүгээр яг энүүхэндээ. Эсвэл ер нь цаашдаа яг энийгээ дагаад бүр олон улсын зээл авахыг ямар хугацаанд гэдэг юм бүр хориглох хэрэгтэй.

Тэрнээс биш энэ хуульд хуулийн нэг заалтаар нь нөгөө заалтаа өөрчилж болохгүй шүү гэдэг юм тавих ямар ч боломжгүй. Энэ зүгээр өөрөө өөрийгөө хуулсан заалт, Үндсэн хуультай ч нийцэхгүй. Тэгэхээр би яах вэ зүгээр Энхтувшин гишүүний сануулж хэлж байгаа нь зөв, аль болохоор тогтвортой мөрдөх ёстой. Тэгэхдээ ер нь нэг ийм хэдүүлээ нөгөө бодит байдалтай байхгүй бол ингээд л энэ нь нэг ийм зөв, энэ нь нэг ийм гайхамшигтай, энэ нь нэг ийм буруу яриад л, энд нэг ийм зөв юм ярих гээд байгаа юм шиг сүүлдээ ингээд нэг л их тийм бодит байдал дээрээ ямар ч хэрэггүй юм хэлэлцээд байгаа байхгүй юу. Аль хэзээний практикт наад 3 хувь чинь бид хэд хэрэглээд л явж байна шүү дээ. Энэ 2 зээлтэйгээ хамт тусдаа гарчихсан. Тэгэхдээ энийг яг ашигласнаар нэг их урсгал зардлыг нэмэх гээд байгаа юм ерөөсөө байхгүй шүү дээ зүгээр л гадаад зээл, эсвэл энэ гадаад зээлийн хэлэлцээрүүдээсээ ямар шугамаараа байдаг юм одоо зогсоогоод татгалзах ёстой. Тэгээд ийм бодит

юмаа ярихгүй байж ингээд худлаа ярьцгаагаад, тэгээд энд нэг их аймаар тийм сахилга бат ярьж нэг худлаа шоудаад л, яг эцсийн дүндээ зарим хөгжлийн асуудал дээр түргэтгэгч эсвэл хөгжлийг дэмжих тэр төслүүд чинь байвал, хэрэгжвэл болно.

Тэгэхээр би яг үнэндээ хэлэхэд анхнаасаа энийг яах вэ ЗГ хөндөөд ороод ирсэн бол зөв байсан гэдэг байр суурь дээр байсан учраас цөөнх болсон. Тэгэхдээ нэгэнт УИХ шийдээд байхад энэ тайлбарууд ерөөсөө ингээд худлаа байна. Энд ингээд л болохгүй шүү, тэр нь дефолт /default/ болно шүү, одоо ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань улс төр заах гэж байна шүү дээ. Та нар одоо ингээд дараа дараагийн Ерөнхий сайдаа огцруулж тоглох гэж байна шүү Франц шиг, өчигдөр бас нэг нөхөр нь мэдэгдэл хийчихсэн байна лээ, ЗГ-ын боогоод ороод ирсэн төсвийг УИХ-ын гишүүд гэдэс дотор луу нь онгойж болохгүй шүү гээд.../минут дуусав/

Н.Наранбаатар: Одоо болсон, одоо нэр аваад дууссан учраас хэдүүлээ, одоо болсон, санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгийн саналаар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа санал хураалт явуулж болно гэж заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар нэгдсэн хуралдаанаар санал хураалгаж дэмжигдсэн саналаар дахин санал хураалгах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. Энэ санал хураалтад оролцсон гишүүдийн 2/3-оор дэмжигдэнэ. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Гишүүд бүгд орж ирээрэй, гишүүд танхимд орж ирээрэй, 36 гишүүн ирцэд орсон байна, одоо хэд байна вэ? 20 гишүүн юунд орсон байна, 21 боллоо. Санал хураалтад бэлэн болоогүй Алтанхуяг, Бадамсүрэн, Батболд, Батболд гишүүн ороогүй байна, Батсүмбэрэл, Батсуурь, Бямбасүрэн ороогүй байна, Ганбаатар, Даваасүрэн, Жавхлан, Мөнхсоёл ороогүй байна, Мэндсайхан, Пунсалмаа, Тэмүүлэн, Энхтүвшин ороогүй, Энхцэцэг ороогүй. Гишүүд санал хураалт, 27 болсон байна. Алтанхуяг ороогүй, Батсүмбэрэл ороогүй, Бямбасүрэн, Ганбаатар, Даваасүрэн, Жавхлан, Пунсалмаа, Тэмүүлэн, Энхцэцэг ороогүй байна, санал хураалт явуулах уу? 27. Бүртгэлийн санал хураалт. 27 гишүүн санал хураалтад бэлтгэсэн байна, 27 хүн байна, тэгэхээр чинь. 27 бэлэн болсон, саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Нэг хуулийн, тийм эхлээд ингэх юм, дэгээрээ дахин санал хураалгах нь зүйтэй гэдгээр эхлээд санал хураагаад, тийм. Дахин санал хураалгах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана. Дараа нь санал жинхэнэ нөгөө томьёолол дээрээ санал хураана, санал хураалт. 66.7 хувиар дэмжсэн тул одоо санал хураалтууд явуулна. Санал хураалтын томьёолол танилцуулъя.

Нэг.Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал. 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувьд тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт, гишүүд. 61,1 хувиар, Цэнгүүн гишүүн дэмжсэн, Баясгалан гишүүнийг дэмжсэнд авъя. Тэгвэл горимын санал гаргачих, саяын Цэнгүүн гишүүн гаргачих уу? Горимын санал гаргачих, Цэнгүүн гишүүний микрофоныг өгье. Өөр Баясгалан гишүүн гаргах уу? Дахих шаардлага байхгүй. Энэ чинь ердийнхөөр шүү дээ. Ердийнхөөр учраас дэмжигдчихсэн, 61.1 хувиар дэмжигдчихлээ, 61.1 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн, тайлбар, хуулийн тайлбар өгье. Дэмжигдчихсэн. Тухайн санал нь ердийнхөөрөө явна гэнэ, хуулийн тайлбар уншаадахъя. Эхлээд нөгөө 2/3-дчихоод эрхээ авчихвал дараагийн саналууд нь ердийнхөөр юм байна. Хуулийн тайлбар сонсъё, уншаадахъя.

Б.Гандулам: Төсвийн байнгын хороо Гандулам тайлбар өгье. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдол гэж байгаа юм. Сая бол эхлээд 2/3-оороо энэ саналаар дахин санал хураалгах шаардлагатай гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 нь дэмжсэн тул дахин ажлын хэсгээс гарсан санал хураалгах саналын томьёоллоо уншиж танилцуулаад дахиад санал хурааж байгаа. Энэ дээр бол 2/3 гэсэн асуудал байхгүй, ердийн олонхоороо дэмжигдээд санал явна.

Н.Наранбаатар: Ойлгомжтой боллоо, зөв явсан байна, саяынх дэмжигдлээ. Дараагийн санал хураалт Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал.

1.Нэгтгэсэн төслийн хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан 3 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт. 67.6 хувиар дэмжигдлээ. Одоо гишүүд анхааралтай байгаарай. Ингэх юм байна, УИХ-ын гишүүн Жаргалангийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирсэн, эхлээд 2/3-оор энийг хураалгах уу гэдгээ шийдчихээд, дахиад саналын томьёоллоороо саяынх шиг энгийнээр санал хураах юм байна, ийм санал ирсэн. Саналын томьёолол, эхлээд 2/3-оороо санал хураачихъя. Тийм саналын томьёолол ийм.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.2 дахь заалтын 3 хувиас гэснийг 2 хувиас гэж өөрчлөх гэдэг дээр санал хураалт явуулъя гэдэг дээр эхлээд 2/3-оор санал хураая, санал хураалт. Энэ уначихлаа, горимын санал, 62.2-оор хүрсэнгүй шүү дээ 2/3. Горимын санал гаргах хүн байна уу, эсрэг гарсан хүмүүсээс? Зарим нь гараад явчихсан байх юм, гишүүд, Мэндсайхан сайд эсрэг гарчхав уу? Хэн, Мэндсайхан сайд. Батсуурь гишүүн горимын санал гаргая.

Ж.Батсуурь: Би санал дарсан боловч эсрэг гарчихсан учраас дахин санал хурааж өгнө үү.

Н.Наранбаатар: Батсуурь гишүүний горимын саналыг дэмжье гэсэн, хүчингүй болгох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя, санал хураалт. 70.3 хувиар дэмжигдсэн тул саяын санал хураалтыг хүчингүй болголоо. Дахиад үндсэн санал хураалт явна. Ирц нэмэгдээд 37 болчихсон учраас 25 хүнээр 2/3 хангагдах юм байна шүү. Одоо үндсэн санал хураалт, санал хураалт. 70.3 хувиар дэмжигдлээ.

Жаргалан гишүүний саналын томьёоллоор, зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя, дахиад уншъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6.1.2 дахь заалтын “3 хувиас” гэснийг “2 хувиас” гэж өөрчлөх. Санал хураалт, гишүүд анхааараарай. 70.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаас гарах танилцуулгыг УИХ-ын гишүүн хэн танилцуулах вэ? Жаргалан гишүүн танилцуулах юм уу? Жаргалан гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

11.15 цаг

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***гурав дахь хэлэлцүүлэг****/*

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оноос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя, ажлын хэсэг хэвээрээ.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.3-т гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн, танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан болно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оноос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбартай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг УИХ-ын гишүүн хэн танилцуулах вэ? Заяабал гишүүн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оноос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

11.17 цаг

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.УЯНГА